Хууль зүйн туслалцааны төвийн
захирлын 2022 оны ... дугаар
тушаалын ... дугаар хавсралт

УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

1.1.Улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 16 дугаар зүйл, Хууль зүйн туслалцааны төвийн дүрмийн “Ес” дэх хэсгийг удирдлага болгон Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Сонгон шалгаруулалтад оролцогчид тавигдах шаардлага

2.1.Монголын Өмгөөлөгчдийн холбооны Өмгөөлөгчдийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн, 25-55 насны өмгөөлллийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээд;

2.2.Шалгаруулалтад орох өмгөөлөгч нь дор дурьдсан бичиг баримтыг сонгон шалгаруулалт зарласан хугацаанд бүрдүүлэн сонгон шалгаруулалтын зар дээрх Хууль зүйн туслалцааны төвийн цахим шуудан руу илгээж бүртгүүлсэн байна. Үүнд:

2.2.1.Сонгон шалгаруулалтад оролцогчийн анкет;

2.2.2.Төрийн албан хаагчийн анкет;

2.2.3. Өмгөөллийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан Өмгөөлөгчдийн нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй талаар Монголын Өмгөөлөгчдийн холбооноос авсан тодорхойлолт;

2.2.4.Дээд боловсролын дипломын хуулбар;

2.2.5. Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар эсхүл цахим лавлагаа;

2.2.6. Иргэний үнэмлэхийн хуулбар;

2.2.7. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ илэрхийлсэн өргөдөл */Өргөдөлд цахим шуудангийн хаяг, утас бичих/*

Гурав. Сонгон шалгаруулалтын бүрэлдэхүүн, түүний үйл ажиллагаа

3.1.Шалгаруулалт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь ажлын хэсгийн ахлагч, ажлын хэсгийн гишүүд, нарийн бичгийн даргаас бүрдэнэ.

3.2.Шалгаруулалтын нарийн бичгийн дарга нь шалгаруулалттай холбоотой дараах үүрэг хүлээнэ.

3.2.1.Шалгаруулалтын зарыг нийтэд зарлан мэдээлэх;

3.2.2.Шалгаруулалтад оролцогчийг бүртгэх бэлтгэлийг хангаж, зохион байгуулах;

3.2.3.Шалгаруулалтад орох тухай өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн үнэн зөв байдлыг шалгах зорилгоор шаардлагатай баримт бичиг, мэдээ, мэдээллийг гаргуулахаар байгууллага, албан тушаалтанд гаргах хүсэлтийн төслийг боловсруулах;

3.2.4.Шалгаруулалтын даалгаврын санг бүрдүүлэх бэлтгэж ажлыг зохион байгуулах, нууцлалыг хамгаалах;

3.2.5.шалгаруулалтын танхим, компьютер техник хэрэгсэл болон шалгалт хэвийн явагдах бусад орчин, нөхцөлийг хангах;

3.2.6.Шалгаруулалтад оролцогчийн биеийн байцаалтыг нягтлан шалгах;

2.2.7.Шалгаруулалтын удирдамжийг шалгаруулалтад оролцогч болон бусад этгээд танилцах боломжтой байхаар Хууль зүйн туслалцааны төвийн цахим хуудсанд байршуулж, мэдээлэх;

3.2.8.Шалгаруулалтын явцад шалгаруулалтад оролцогчдод хяналт тавих, шалгаруулалтын явцыг баримтжуулах;

3.2.10.Шалгаруулалтын хувийн хэргийг хөтлөх;

3.3.Сонгон шалгаруулах ажлын дүнг сонгон шалгаруулалт зохион байгуулсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор эцэслэн Хууль зүйн туслалцааны төвийн захиралд танилцуулах, томилох саналыг оруулж, дүнг олон нийтэд цахимаар нээлттэй мэдэгдэнэ.

Дөрөв. Сонгон шалгаруулалтын зарыг нийтэд зарлах, оролцогчийг бүртгэх

4.1. Сонгон шалгаруулалтын зарыг нийтэд зарлах

4.1.1.Сонгон шалгаруулалтын зарыг Хууль зүйн туслалцааны төв, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбооны цахим хуудсаар нийтэд зарлана.

4.2.Сонгон шалгаруулалтын бүртгэл

4.2.1.Сонгон шалгаруулалтын бүртгэлийг цахим хэлбэрээр явуулна.

4.2.2.Сонгон шалгаруулалтад оролцогчийг бүртгэх ажиллагаа сонгон шалгаруулалтын зарыг зарласан өдрөөс эхэлж, зард заасан материал хүлээн авах эцсийн өдөр дуусна.

4.2.3.Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхтэй холбогдон гарах зардлыг оролцогч өөрөө хариуцна.

4.2.4.Сонгон шалгаруулалтад оролцогч бүртгүүлэхдээ сонгон шалгаруулалтын тойргоо сонгож, сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт, улсын өмгөөлөгчийн сонгон шалгаруулалтад оролцогчийн анкетад сонгосон тойргоо заавал бичсэн байна.

4.2.5.Сонгон шалгаруулалтад оролцогч нэг тойргийг сонгох бөгөөд хэд хэдэн тойрогт сонгон шалгаруулалтад оролцож болохгүй.

4.3.Сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн шалгалт эхлэхээс 2 хоногийн өмнө энэ журмын “Хоёр” дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид шалгалтад орох эрх олгож, нэрсийг баталгаажуулан утсаар болон оролцогчийн и-мэйл хаягаар мэдэгдэнэ.

4.4.Ажлын хэсэг дор дурьдсан үндэслэлээр сонгон шалгаруулалтад бүртгэхээс татгалзана.

4.4.1.Энэ удирдамжийн “Хоёр” дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй;

4.4.2.Энэ удирдамжийн 2.4-т заасан баримт бичгийн дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн;

4.4.3.Сонгон шалгаруулалтад оролцохоос өөрөө татгалзсан.

Тав. Шалгалтын хамрах хүрээ, хугацаа

5.1.Сонгон шалгаруулалтыг бичгийн болон ярилцлагын хэлбэрээр явуулах бөгөөд ярилцлагын шатанд нарийн бичийн дарга тэмдэглэл хөтөлнө. Шалгаруулалтад дараахь үзүүлэлтийг үндэслэл болгоно. Үүнд:

5.1.1.Хууль хэрэглээ;

Ач холбогдол:Улсын өмгөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахдаа хуулийг зөв хэрэглэж, үндэслэл бүхий тайлбар хийх нь гэмт хэргийг зөв зүйлчлэх, оногдуулах ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, гэм буруугүйд тооцуулахад чухал нөлөөтэй.

5.1.2.Логик сэтгэлгээ;

Ач холбогдол:Тохиолдол, өгөгдөлүүдийг дэс дараалалд оруулан эмхлэн цэгцлэх, задлан шинжлэх замаар мэдээлэл олж авах, аливаад нухацтай хандаж, нягтлан шалгах, эргэлзэх замаар алдаа дутагдлыг олж илрүүлэх, эргэцүүлэн дүгнэлт гаргахад ач холбогдолтой.

5.1.3.Ярих ур чадвар;

Ач холбогдол: Сонгон шалгаруулалтад оролцогчийг хувь хүн талаас нь дүгнэх, яагаад улсын өмгөөлөгчөөр ажиллах хүсэлтэй байгаа, ирээдүйд улсын өмгөөлөгчийн нэр хүндийг дээшлүүлэхэд нөлөөлж чадахуйц хүн мөн эсэх, төлбөрийн чадваргүй яллагдагчийн эрхийг хангаж ажиллах, төрөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлэх эсэхийг дүгнэхэд ач холбогдолтой.

5.2.Сонгон шалгаруулалтын хугацааг дараах байдлаар зохион байгуулна:

5.2.1.Бичгийн шалгалтын үргэлжлэх хугацаа 90 минут.

5.2.2.Ярилцлагын шалгалтын үргэлжлэх хугацаа шалгалтад оролцогч тус бүрт 5 минут байна.

5.3.Шалгаруулалтад тухайн салбарт улсын өмгөөлөгчөөр ажилд орохоор 1 хуульч бүртгүүлсэн тохиолдолд түүнээс энэхүү удирдамжийн 4.1, 4.2-д заасны дагуу шалгалт авч, дүгнэлтийг ажлын хэсэг гаргана.

Зургаа.Шалгалтын үнэлгээ

6.1.Шалгалтын нийт оноо 100 оноо байх бөгөөд бичгийн шалгалт 60 оноо, ярилцлагын шалгалт 40 оноо байна.

6.2.Бичгийн шалгалтад дараах байдлаар үнэлгээ өгнө.

6.2.1.Зөв бичих, найруулга зүй 20 оноо

6.2.2.Хууль хэрэглээ 20 оноо

6.2.3.Логик сэтгэлгээ 20 оноо

6.3. Шалгаруулалтад хамгийн өндөр оноо авсан өмгөөлөгчийг уг албанд тушаалд тэнцсэнд тооцох бөгөөд улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүдийн нийт үнэлгээний дунджаар гаргана.

6.4.Ажлын хэсэг шалгаруулалтын дүнг олон нийтэд цахимаар нээлттэй зарлаж, уг албан тушаалд хамгийн өндөр оноо авсан иргэнийг томилуулахаар Төвийн захиралд санал оруулна.

6.5.Шалгаруулалтад хамгийн өндөр оноо авсан хуульч уг албан тушаалд томилогдохоос татгалзсан тохиолдолд Ажлын хэсэг онооны дараалаар дараагийн иргэнийг томилохоор Төвийн захиралд санал оруулна.

Долоо.Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах хэлбэр

7.1.Нийслэл дэх салбарт ажиллах улсын өмгөөлөгчийн сонгон шалгаруулалтыг танхимаар зохион байгуулна.

7.2.Улсын өмгөөлөгчийн сонгон шалгаруулах ажлыг 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 14:00 цагт Хууль зүйн туслалцааны төвийн байр /Монгол Улс, Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо Бага тойруу-49, Мэдээлэл технологийн Үндэсний паркийн байр 4 давхар/-ны 404 тоот хурлын танхимд зохион байгуулна.

7.3. Нийслэлийн салбарт ажиллах улсын өмгөөлөгчийн шалгаруулалтад оролцогчид Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж буй хорио цээрийн дэглэм суларсантай холбоотой Хууль зүйн туслалцааны төвийн байранд биечлэн ирж шалгалтанд оролцоно.

7.4. Орон нутаг дахь салбарт ажиллах улсын өмгөөлөгчийн сонгон шалгаруулалтыг цахимаар зохион байгуулж болно.

7.4.1.Ажлын хэсгээс цахимаар сонгон шалгаруулалтад оролцогчдод “Google meeting” програмын нэвтрэх нэр, нууц үгийг хүргүүлнэ.

7.4.2.Улсын өмгөөлөгчийн сонгон шалгаруулалтыг 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатар хотын цагаар 14:00 цагт эхэлнэ.

7.4.3. Бичгийн шалгалтын үргэлжлэх хугацаа 90 минут дуусмагц 10 минутын дотор Хууль зүйн туслалцааны төвийн info@lac.gov.mn цахим хаягт илгээнэ. Заасан хугацаанд илгээгээгүй тохиолдолд материалыг хүлээн авахгүй.

7.4.4.Ярилцлагын шалгалтын цагийг оролцогчдод тухайн үед нь мэдэгдэнэ.

7.4.5.Сонгон шалгаруулалтад цахимаар оролцоход техник, тоног төхөөрөмж, интернэт сүлжээ, компьютерийн саадгүй ажиллагааг оролцогч өөрөө хариуцна.Хэрэв шалгалтын явцад тоног төхөөрөмж, интернэт сүлжээ тасарсан тохиолдолд шалгалтыг хүчингүйд тооцно.

Найм.Сонгон шалгаруулалттай холбогдуулан гомдол гаргах.

8.1.Өргөдөл гаргагч нь шалгалт оруулахаас татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрвөл шалгалт эхлэхээс 2 хоногийн өмнө Хууль зүйн туслалцааны төвийн захиралд гомдол гаргаж болно.

8.2. Сонгон шалгаруулалттай холбоотой гомдлыг шалгалт дуусан өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан комисст гаргана.

-oOo-

УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧИЙН ТУСЛАХ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

1.1.Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчийн туслахын сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Сонгон шалгаруулалтад оролцогчид тавигдах шаардлага

2.1.Улсын өмгөөлөгчийн туслахын орон тоонд бүртгүүлэх иргэн дараах шаардлагыг хангасан байна.

2.1.1.Хууль, эрх зүйн чиглэлээр бакалвар зэрэгтэй;

2.1.2.Комьютерийн хэрэглээний программыг бүрэн эзэмшсэн;

2.1.3. Албан бичиг төлөвлөх, боловсруулах, мэдээ тайлан нэгтгэх, судалгаа хийх чадвартай

2.2. Шалгаруулалтад орох иргэн нь дор дурьдсан бичиг баримтыг сонгон шалгаруулалт зарласан хугацаанд бүрдүүлэн Хууль зүйн туслалцааны төвд цахимаар өгч бүртгүүлсэн байна. Үүнд:

2.2.1. Төрийн албан хаагчийн анкет

2.2.2. Дээд боловсролын дипломын хуулбар

2.2.3. Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар /нийгмийн даатгалын дэвтрийн эхний нүүр болон ажилд орсон, гарсан тушаалын бичилт бүхий хуудас орно/

2.2.4 Иргэний үнэмлэхний хуулбар

2.2.5. Ажиллах хүсэлтээ илэрхийлсэн бичгээр гаргасан өргөдөл

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцогчийг бүртгэх

3.1.Энэхүү удирдамжийн 3.2-т зааснаас бусад тохиолдолд өргөдөл гаргагчид утсаар болон оролцогчийн и-мэйл хаягаар мэдэгдэж бүртгэнэ.

3.2. Ажлын хэсэг дор дурьдсан үндэслэлээр сонгон шалгаруулалтад бүртгэхээс татгалзана.

3.2.1.Энэ удирдамжийн “Хоёр” дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй

3.2.2. энэ удирдамжийн 2.4-т заасан баримт бичгийг дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн

3.2.3. Сонгон шалгаруулалтад оролцохоос өөрөө татгалзсан

Дөрөв.Шалгалтын хамрах хүрээ, хугацаа

4.1.Сонгон шалгаруулалтыг сорилго болон ярилцлагын хэлбэрээр явуулах бөгөөд ярилцлагын шатад оролцогч тус бүр тэмдэглэл хөтөлнө. Шалгаруулалтад дараахь үзүүлэлтийг үндэслэл болгоно. Үүнд:

4.1.1.Ерөнхий мэдлэг шалгах

4.2.1.Ярих ур чадвар

4.2.Сонгон шалгаруулалтын хугацааг дараах байдлаар зохион байгуулна:

4.2.1.Бичгийн шалгалтын үргэлжлэх хугацаа 50 минут;

4.2.2.Ярилцлагын шалгалтын үргэлжлэх хугацаа шалгалтад оролцогч тус бүрт 5 минут байна.

4.3.Шалгаруулалтад улсын өмгөөлөгчийн туслахаар ажилд орохоор 1 иргэн бүртгүүлсэн тохиолдолд түүнээс энэхүү удирдамжийн 4.1, 4.2-т заасны дагуу шалгалт авч, дүгнэлтийг ажлын хэсэг гаргана.

Тав.Шалгалтын үнэлгээ

5.1.Шалгалтын нийт оноо 100 оноо байх бөгөөд сорилгын шалгалт 50 оноо, ярилцлагын шалгалт 50 оноо байна.

5.3.Шалгаруулалтад хамгийн өндөр оноо авсан иргэнийг уг албан тушаалд тэнцсэнд тооцох бөгөөд сонгон шалгаруулах ажлыг зоионх байгуулах ажлын хэсгийн гишүүдийн нийт үнэлгээний дунджаар гаргана.

5.4.Ажлын хэсэг шалгаруулалтын дүнг олон нийтэд цахимаар нээлттэй зарлаж, уг албан тушаалд хамгийн өндөр оноо авсан иргэнийг томилуулахаар Төвийн захиралд санал оруулна.

5.5.Шалгаруулалтад хамгийн өндөр оноо авсан иргэн уг албан тушаалд томилогдохоос татгалзсан тохиолдолд Ажлын хэсэг онооны дараалаар дараагийн иргэнийг томилохоор Төвийн захиралд санал оруулна.

Зургаа.Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах хэлбэр

6.1.Улсын өмгөөлөгчийн туслахын сонгон шалгаруулалтыг танхимаар зохион байгуулна.

6.2.Улсын өмгөөлөгчийн туслахын сонгон шалгаруулах ажлыг 2022 оны 02 дугаар сарын 25-ний өдрийн 14.00 цагт Хууль зүйн туслалцааны төвийн байр /Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо Бага тойруу-49, Мэдээлэл технологийн Үндэсний паркийн байр 4 давхар/-ны хурлын танхимд зохион байгуулна.

6.3.Сонгон шалгаруултад тавигдах шаардлагыг хангасан оролцогчдод сонгон шалгаруулалтыг зохион байгуулах өдрөөс 2 хоногийн өмнө товыг мэдэгдэнэ.

Долоо. Сонгон шалгаруулалттай холбогдуулан гомдол гаргах

7.1.Өргөдөл гаргагч нь шалгалтад оруулахаас татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрвөл шалгалт эхлэхээс өмнө 2 хоногийн өмнө Хууль зүйн туслалцааны төвийн захиралд гомдол гаргаж болно.

7.2.Сонгон шалгаруулалттай холбоотой гомдлыг шалгалт дууссан өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан комисст гаргана.

-oOo-